

Монголын түр орогнох байрны кластер

Танилцуулах уулзалт 17.04.2019


Яагаад зохицуулалт гэж?



Энэтхэгийн далайн Цунамигийн дараах Шри Ланка улсад өгсөн шуурхай хорогдох байр болон байнгын байшингууд



Дэлхий нийтийн Кластер систем



- 2004 онд болсон Энэтхэгийн далайн Цунамигийн дараа хүмүүнлэгийн нйигэмлэгүүд бүх оролцогч нарт зориулсан **дэлхий нийтийн зохицуулалтын механизмын хэрэгцээ** байгааг ухаарсан.
- НҮБ, Улаан загалмай (ОУУЗУХСНХ) мөн ТББ-уудын удирдлагаас бүрдсэн IASC (Байгууллага хоорондын байнгын хороо) нь хамтарсан зохицуулалтын механизмыг хүлээн зөвшөөрөн боловсруулах ажлыг хариуцах болов.
- **2005 онд “кластер систем” нь** хүмүүнлэгийн оролцооны 11 гол салбаруудад **танилцуулагдсан.**

Кластер багуудыг хэн удирддаг вэ?

- Кластер бүрийг нэг эсвэл хоёр НҮБ-ын тухайн салбарын туршлага болон чадавхитай байгууллага удирдана, (хүнсний аюулгүй байдалд ХХАА байгууллага болон дэлхийн хүнсний хөтөлбөр, эрүүл мэндэд дэлхийн эрүүл мэндийн байгууллага г.м
- “Түр орогнох байрны кластер”-ийн удирдлага нь зэвсэгт мөргөлдөөний бүсэд удирдах НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал хариуцсан дээд комиссар болон **байгалийн гамшгийн дараах орогнох байрны кластерийг зарлан хуралдуулдаг ОУУЗУХСНХ** нарын хооронд хуваагддаг.

Why IFRC as Convener of the Shelter Cluster after Natural disasters?



Кокс зах дахь хулсны хуваарилалт, Бангладеш


- ОУУЗУХСНХ-ны яаралтай үеийн хариу үйлдэл болон сэргээн босголтын төсвийн 30-40% нь орогнох байртай холбогдолтой бараа бүтээгдэхүүнд зарцуулагддаг (өрхийн хүнсний бүс бүтээгдэхүүн, орогнох байрны материал, барилгын тусламж г.м)
- ОУУЗУХСНХ, бүх үндэсний нийгэмлэгүүд болон ОУУЗХ нар нийлээд дэлхий даяарх **УЗУХС хөдөлгөөний яаралтай үеийн түр орогнох байрны хамгийн том нийлүүлэгч гэж тооцоологддог.**

Кластерийн идэвхижилт

- Кластер систем нь *“удирдах чадавхи, зохицуулалт, туслалцаа хүргэлт болон хамгаалалт нь хямралын хэмжээ, түвэгтэй байдал мөн хойшлуулшгүй байдалтайгаа нийцэхгүй үед”* идэвхждэг бөгөөд энэ нь ихэвчлэн тухайн үндэсний засгийн газар нь олон улсын тусламж хүсэх нөхцлийг хэлнэ
- Кластерууд нь *“систем өөрөө (хүмүүнлэгийн) үндэсний удирдлагуудад болон газар дээрх чадавхид хурдтай мөн үр дүнтэйгээр туслалцааг хүргэх байдлыг хангаж байх хэрэгтэй”*

*IASC Reference Module for Cluster Coordination at Country Level

Идэвхитэй кластерууд 2019



Кластерийн гол гүйцэтгэх үүргүүд

- Хандлага болон хуулбарлалтыг арилгах тал дээр зөвшилцлийн мөрийн хөтөлбөрийг **үйлчилгээний түгээлтийг дэмжих** байдлаар хангах
- **Хэрэгцээний үнэлгээний зохицуулалт, ялгаатай байдлын шинжилгээ болон эрэмблэлтээр** хүмүүнлэгийн зохицуулагч/хүмүүнлэг улсуудын багийн хариу үйлдлийн стратеги шийдвэр гаргалтыг мэдээлэх
- Салбаруудын төлөвлөгөө, стандартуудын баримтлал болон санхүүжилтын хэрэгцээг хамруулсан **төлөвлөлт ба бодлого боловсруулалт**
- Кластерийн оролцогч болон нэрвэгдсэн хүн амын өмнөөс тодорхойлогдсон чухал байдлууд руу хандуулахыг **сурталчилах**
- Тохиромжтой үеийн засварын ажиллагааг санал болгон кластерийн бодлого болон үр дүнг **хянах мөн тайлагнах**
- **Хэрэгцээтэй болон чадавхи оршиж буй газар бэлэн байдлын төлөвлөлт/бэлтгэлжилт/үндэсний хүчин чадлыг бэхжүүлэх**

*IASC Reference Module for Cluster Coordination at Country Level

Дадлага дээр хэрхэн харагдаж байна вэ?



Түр орогнох байрны оролцогчдын уулзалт зарлан: → хэрэгцээний үнэлгээг зохицуулах → хариу үйлдлийн бодлого хэлэлцэх → хамтарсан стандарт болон хандлагыг боловсруулан зөвшөөрөх → хамрагдалт болон ялгаатай байдлын тухай мэдээллээр хангах → мэргэжлийн чиг үүрэг бий болгох → тусламж хүртэгчийн өмнөөс ухуулга хийх → сэргээн босголтыг дэмжих → бэлэн байдлын төлөвлөлт, орон нутгийн хүчин чадлыг сайжруулах г.м

Түр орогнох байрны кластер баг

- Кластерийн зохицуулалтын багийн гол үүрэгтнүүд:
 - Зохицуулагч
 - Мэдээллийн менежер
 - Техникийн зохицуулагч
 - Нэмэлт үүрэгтнүүдийг хэрэгцээнээс шалтгаалан элсүүлж болно, жишээ нь:
 - Сэргээн босголтын зөвлөх – байгаль орчны зөвлөх – Орон сууц, газар болон өмчийн (HLP) хуулийн зөвлөх – Газарзүйн зураглал/GIS мэргэжилтэн
 - Хэвлэл мэдээлэл болон харилцаа холбоо/засгийн газрын харилцаа холбооны ажилтан
- Түр орогнох байрны кластер баг нь **УЗУХС яаралтай үеийн уриалга** болон бусад түнш нараар санхүүждэг
- Баг нь **глобал сюржийн чадавхи** болон **сургагдсан мөн туршлагатай албан хаагч бүхий бүрэлдэхүүнээр** хангагдсан байдаг
- Түр орогнох байрны кластер нь **аливаа байгууллагуудын хамаарал бүхий мэргэшсэн мөн туршлагатай албан хаагч** нарыг хүлээн зөвшөөрдөг

Монголын түр орогнох байрны кластер

- Монгол улсад Засгийн газар нь кластер системийг өөрчлөн байнгын зохион байгуулалттай болгон баталсан

Кластер дундын зохицуулалт	RCO/НС	Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)
Кластер/Салбарууд	Удирдах байгууллага	Засгийн газрын гол холбоос болон товчлол
Хөдөө аж ахуй	ХХАА байгууллага	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам (MOFALI)
Зуслангын зохицуулалт болон менежмент	ОУ шилжилт хөдөлгөөний байгууллага	Нийслэлийн онцгой байдлын газар (UB city CEMA)
Эхэн үеийн сэргээн босголт	НҮБХХ	Барилга, хот байгуулалтын яам (MCUD)
Боловсрол	ЮНИСЕФ & SC	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (MECSS)
Орогнох байр & Хүнсний бүс бүтээгдэхүүн	МУЗН (ОУУЗУХСНХ)	Нийслэлийн ЗДТГ? Лавлах
Хоол хүнс	Дэлхийн зөн	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам (MOFALI)
Эрүүл мэнд	ДЭМБ	Эрүүл мэндийн яам (MoH)
Ложистик ба онцгой үеийн харилцаа холбоо	ЮНИСЕФ	Зам, тээврийн хөгжлийн яам(MoRT), Иргэний нисэхийн ерөнхий газар (CAA), Гаалийн ерөнхий газар (MGCA)
Хоол тэжээл	ЮНИСЕФ	Эрүүл мэндийн яам (MoH)
Хамгаалалт (Жендэрт суурилсан хүчирхийлэл болон хүүхэд хамгааллын дэд кластер)	НҮБ-ын Хүн амын сан ба ЮНИСЕФ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам(MoPDSP) Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (NCAV)
Ус, ариун цэвэр	ЮНИСЕФ	Усны үндэсний хороо (NWC)

МУЗН-ийн үүрэг юу вэ?

- Хүмүүнлэгийн улсуудын багийн уулзалтуудад түр орогнох байрны кластерийн төлөөлөгчийн хувиар оролцох
- ОБЕГ, НОБГ болон хотын засаг захиргаа зэрэг холбогдох байгууллагуудтай харилцаа холбоогоо тодорхойлон түүнийгээ хадгалах
- Түншлэгч байгууллагуудтай санал нэгдсэнчлэн түр орогнох байрны кластерийн хурлыг зарлан хуралдуулж бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгагдсан бэлтгэлжилтийн ажиллагааны дараах ажлыг эхлүүлэх

Асуулт?

